



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/259

Алтай хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “Авлигыг би авахгүй, бас өгөхгүй аян”-ыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүн:

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)


(Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

(Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар)

Нарийн бичгийн дарга: (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

3. Аяны удирдамж батлуулан зохион байгуулж, дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР